



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар

01/4877

Улаанбаатар хот

«Баянгол дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил,
хамгааллын хэлтсийн данс бүртгэлд
хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхийн зөн Монгол Олон улсын байгууллага, иргэдээс хандивласан нийт 21,050,610.00 (хорин нэгэн сая тавин мянга зургаан зуун арван) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Баянгол дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс (Б.Даваажаргал)-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс (Б.Даваажаргал)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн дугаар тушаалын хавсралт

Бүртгэлд авах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар, үзүүлэлт	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ		Хандивлагч байгууллага	Хөрөнгийн эх үүсвэр
							Нэгжийн үнэ	Нийт үнэ		
1	Номын сангийн шүүгээ	дсл хавтан	2024	сайн	ш	1	5,010,000.00	5,010,000.00	Дэлхийн зөн Монгол Олон Улсын байгууллага	Хандив
2	Түшлэгтэй сандал	Хятад	2024	сайн	ш	15	134,830.00	2,022,450.00		
3	Уулзалтын ширээ	Хятад	2024	сайн	ш	12	212,430.00	2,549,160.00		
4	Хувцасны болон номын шүүгээ	дсл хавтан	2024	сайн	ш	1	1,600,000.00	1,600,000.00	Иргэд	Хандив
5	Хүүхдийн ширээ	Хятад	2024	сайн	ш	1	2,800,000.00	2,800,000.00		
6	Хүүхдийн хувцасны шүүгээ	дсл хавтан	2024	сайн	ш	1	1,450,000.00	1,450,000.00		
7	Ор болдогч ногоон буйдан	Хятад	2024	сайн	ш	1	850,000.00	850,000.00	Иргэд	Хандив
8	Уулзалтын буйдан шаргал	Хятад	2024	сайн	ш	1	1,500,000.00	1,500,000.00		
9	Зөөлөн сандал цэнхэр	Хятад	2024	сайн	ш	2	300,000.00	600,000.00		
10	Сэтгүүлийн ширээ 3 хөлтэй	Хятад	2024	сайн	ш	1	220,000.00	220,000.00		
11	Сэтгүүлийн ширээ цагаан	Хятад	2024	сайн	ш	1	280,000.00	280,000.00		
12	Гал тогооны тавилга	Хятад	2024	сайн	ш	1	500,000.00	500,000.00		
13	Гутлын төмөр шүүгээ 15 нүдтэй	Хятад	2024	сайн	ш	1	405,000.00	405,000.00		
14	Төмөр шүүгээ 12 нүдтэй	Хятад	2024	сайн	ш	1	396,000.00	396,000.00		
15	Төмөр шүүгээ 9 нүдтэй	Хятад	2024	сайн	ш	1	378,000.00	378,000.00		
16	Хиншүү сорогч	Euro lux	2024	сайн	ш	1	210,000.00	210,000.00		
17	Дээжний хөргөгч	Hyund	2024	сайн	ш	1	280,000.00	280,000.00		
Тавилга эд хогшлын дүн								21,050,610.00		
НИЙТ БҮРТГЭХ ДҮН								21,050,610.00		